

Агуулга

1. ОРДЫН ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төслийн товч танилцуулга	2
1.2 Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө.....	3
1.3 Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал.....	3
2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
2.1 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	5
2.1.1 Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл	5
2.1.2 Хөрсний бохирдол.....	6
2.1.3 Усны бохирдолт	6
2.1.4 Амьтны болон ургамлын аймагт үзүүлж болзошгүй нөлөөлөл.....	7
2.2 Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, давтамж, нөлөөлөл, үргэлжлэх хугацаа	7
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	9
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	10
5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	16
6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	17
7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	18
8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	23
10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	25
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ 26	
12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА	27

1. ОРДЫН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн товч танилцуулга

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК нь Говь-Алтай аймгийн Чандмань сумын нутагт орших Шар хоолой хэмээх нэртэй газарт ашигт малтмал ашиглалтын 905А, 11965А, 14217А тоот тусгай зөвшөөрөл бүхий 483.53 га талбайг эзлэн байрлана. Орд нь Алтайн нурууны зүүн өмнөд талын салбар Гичгэний нурууны уулс хоорондын хотгорын нэг болох Шар хоолойн хотгорт далайн түвшнээс дээш 2300 гаруй метрийн өндөрт байрлана.

Тус уурхай нь 1979 оноос ашиглалт явуулж ирсэн бөгөөд 1994 онд хувьчлагдан 2006 оноос манай компани тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа явуулж байна. Анх 1969 онд Зээгтийн нүүрсний ордод эрэл хайгуулын ажил явуулсан (Д.Дашцэрэн нар) ба нүүрсний 4.48 сая тонн нөөц тооцсон. Энэ үед 7 канав, 20 шурф, 18 цооногийн өрөмдлөгийн ажил хийсэн байна.

1979 онд Д.Оросоогийн удирдсан анги ордод нарийвчилсан хайгуул хийсэн. Нарийвчилсан хайгуулаар 10 канав, 133 шурф (116 шурфыг нөөцийн тооцоонд ашигласан), 54 цооногийн өрөмдлөг (50 цооногийг нөөцийг тооцоонд ашигласан)-н ажил хийж, балансын нөөц болон урьдчилан үнэлсэн, таамаг нөөцүүдийн тооцоо хийжээ.

Үүнээс хойш тус ордод нарийвчилсан ба ашиглалтын хайгуулын нэмэлт ажил явагдаагүй ба 2005 онд “Түлш-Алтай” ХХК-тай байгуулсан менежментийн гэрээний дагуу 2006 оноос “Сэкер Ресорсус Монголиа” ХХК нөөц өсгөх нарийвчилсан хайгуулын ажлыг хийж эхэлсэн.

Зураг №1.Талбайн байршил



“Сэкер Ресорсус Монголиа” ХХК -нь байгаль орчныг хамгаалах талаар Монгол улсын хууль тогтоомж, стандартуудыг даган мөрдөж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНҮ)-д тусгагдсан зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэн төслийн үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх зорилготойгоор ажиллаж байна.

2020 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, 2023 онд Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг ашиглалтын талбайнуудад эрх бүхий мэргэжлийн байгууллагаар шинэчлэн боловсруулуулж холбогдох байгууллагаар батлуулсан.

Мөн Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу 2011 оноос эхлэн археологийн хайгуул судалгаа, 2012 онд археологийн малтлага судалгааны ажлуудыг шат дараатайгаар хэрэгжүүлсэн.

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр болон биелэлтийг БОАЖЯ-аар жил бүр батлуулж, мөрдлөг болгон ажиллаж байна.

1.2 Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

Зээгтийн ордын 2025 оны хөрс хуулалт, нүүрс олборлолтын төлөвлөгөөг 2024 оны Тодотгол ТЭЗҮ-ний дагуу 1 дэх жилийн төлөвлөгөөгөөр хөрс хуулалт 54,311 мян.м³, үйлдвэрлэлийн нөөцөөр 10,001 мян.тн нүүрс олборлохоор төлөвлөсөн.

Хөрс тээврийн зай дунджаар 3,9 км нүүрс тээврийн зай 3км байхаар ТЭЗҮ-нд тусгагдсан. Хөрс тээврийг автосамосвалуудаар тээвэрлэж гадаад овоолгод буулган, нүүрсний давхаргын үе, чулуун үет давхаргуудын хооронд ялган ангилна.

Шивээ хүрэнгийн боомтоор 1/3 коксжих нүүрсийг БНХАУ руу экспортод гаргах бөгөөд эрчим хүчний нүүрсийг Бургастайн боомтоор технологийн туршилтын зорилгоор 3-4 дүгээр улиралд тээвэрлэх болон орон нутгийн өвлийн хэрэгцээг хангахаар төлөвлөн ажиллаж байна.

1.3 Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал

Физик газар зүй


Орд нь Алтайн нурууны зүүн өмнөх талын салбар уулс болох Түгээн, Хар-Аргалантын нуруудын хооронд орших Бигэрийн хотгорт оршино. Орд нь 2300 гаруй метрийн өндөрлөгтэй (далайн түвшнээс дээш) гадаргуу бүхий талбайг эзэлнэ. Чулуун нүүрсний Зээгтийн орд нь Алтай хотоос 250 км, Чандмань сумаас баруун хойш 8 км зайд оршино. Ордод ойр байрлах хилийн боомт нь БНХАУ-д нэвтрэх Говь-Алтай аймгийн Бургастайн боомт 230 км-т, Шивээ Хүрэнгийн боомт 300-350 км зайтай тус тус оршино. Газарзүйн байршлын солбицол:

ХӨ 42° 2' 50" - 45° 22' 50"

ЗУ 97° 51' 30" - 97° 54' 30"

Физик газарзүйн мужлалаар уг талбай нь Алтайн уулархаг их мужийн Говь-Алтайн бүсэд багтдаг. Баруун хойноос зүүн урагшаа сунаж тогтсон Алтайн салбар уулс болох Гичгэний нурууны ард оршино. Уулс нь гүн сайр, жалгаар хүчтэй хэрчигдсэн байх ба талбайн өмнөд хэсгээр орших уулс нь голчлон эгц хажуутай, шовх оройтой, хойноосоо урагш чиглэлтэй гүн хавцал, жалгаар хүчтэй хэрчигдсэн байдалтай. Түүний заримаар нь авто машин, ердийн хөсгөөр нэвтрэх боломжтой. Талбайн үнэмлэхүй өндөр нь урдаасаа хойшлох тусам өндөрсөх хандлагатай. Үнэмлэхүй өндөр нь дунджаар 2200-2500 м байна.

Зураг №3. Байгалийн бүс бүслүүр ба эко систем.



Уур амьсгал

Эх газрын эрс тэс уур амьсгалтай. Жилийн дундаж температур $-1,8$ -аас $+3,4$ $^{\circ}\text{C}$ -т хэлбэлзэнэ. Хүйтний улирал үргэлжлэх хугацаа 6 сар ба түүнээс дээш. Гэхдээ 10-р сараас 4-р сар хүртлэх хасах температуртай байдаг. Өвөл хамгийн багадаа буюу $-22,3$ $^{\circ}\text{C}$, дунджаар -31 $^{\circ}\text{C}$ байна. Тунадас 150-200 мм, өвөл -31 $^{\circ}\text{C}$ дундаж температуртай, зун хамгийн их буюу $+30$ $^{\circ}\text{C}$ орчим байсан гэж тэмдэглэгджээ. Хамгийн халуу үе 7-р сард $+26$ $^{\circ}\text{C}$ дундаж температуртай байна. Зун зарим өндөр уулсынхаа оройгоор цас хайлалгүй жил өнжих нь ч бий. Тунадасны хэмжээ олон жилийн дунджаар 48,6-214,8мм. Сарын дундаж чийглэг 28-29%, жилийн дундаж чийглэг 70% байдаг. 4, 5-р сард 25м/с хүртэл хурдтай хүчтэй шороон шуурга болдог.

Хөрс

Тусгай зөвшөөрөлтэй ашиглалтын талбайд цайвар хүрэн хөрсний хэв шинж тархах бөгөөд Монгол орны хөрс газарзүйн мужлалаар говийн их мужийн Монголын өрнөд мужийн Бигэр-Баянголын 30-р тойрогт хамрагдана.

Дутуу хөгжилтэй цайвар хүрэн хөрс Тусгай зөвшөөрөлтэй талбайд гүвээ толгодын орой болон ар хажуу хэсгээр ихэвчлэн тархана. Хатуу суурь чулуулгийн элювийн хурдас дээр тогтворжих бөгөөд хэмхдэс сайр чулуу ихтэй байдаг онцлогтой.

Цайвар хүрэн хөрс Лицензтэй талбайн дийлэнх хэсгээр тархах бөгөөд гол онцлог нь гадаргын хувьд харьцангуй тэгшивтэр газруудад тархана. Хөрсний гадаргын ихэнх хэсэг ургамалгүй байдаг учраас салхины үлээгдэлд хялбар өртөж том ширхэгтэй элс, жижиг сайр чулуугаар бүрхэгдсэн байна.

Далд глейрхэг (нугархаг) цайвар хүрэн хөрс Энэ хөрс нь талбайн ухаа толгодын хоорондох хотгор газрыг дагаж тархах бөгөөд үетэн алаг өвст ургамал бүрхэх энд 50-60 хувь хүрнэ. Энэ хөрсөнд орчин тойрны өндөрлөг газраас гадаргын урсацаас ирж хуралдах эс чийгийн нөлөөгөөр улирлын чанартай түр зуурын нэмэгдэл чийг бий болж нугархаг шинж үүсэх нөхцөл бүрддэг байна.

Эртний цэвдгийн үлдмэл шинжтэй хар хүрэн хөрс Энэ хөрс нь лицензтэй талбайд нүүрсний карьерын орчимд гүдгэрдүү газрын оройгоор багахан хэмжээний талбай эзлэн тархсан байна. Эртний цэвдэгт үзэгдлийн ул мөр болох шаантаг хэлбэртэй, ихэнхдээ карбонатгүй бага зэрэг ялзмагжсан нунтаг шороогоор дүүргэгдсэн. Энэхүү эртний цэвдгийн үлдмэл шинж морфологийн хувьд хадгалагдаж хөрсөн бүрхэвчийг алаг цоог шинжтэй болгож байна.

Ургамал

Бидний судалгаа явуулсан Зээгтийн нүүрсний уурхайн урд талд Монгол Алтайн нурууны төгсгөл болох Эмээлцэгийн нуруу, Гичгэний нуруу зэрэг уул, нуруудын оргил хэсгээр тархах өндөр уулын хуурай хээрийн жижиг дэгнүүлт үетэн-бушилзат, жижиг дэгнүүлт үетэн-алаг өвс-бушилзат түгээмэд тохиолдоно. Эмээлцэгийн нурууны ар хөндийд нам уулсын уулын хээрийн элдэв өвс-хялганат, тэгш тал хөндийд элдэв өвс хялганат, ерхөг-хялганат дунд зэрэг талхлагдсан бүлгэмдэл зонхилон тархана.

Мөн нуурт хонхор, давсархаг газрын ургамалжилт тохиолдлоо. Өндөр уулын хээрийн бүсийн цайвар хүрэн хөрстэй газар *Stipa gobica*, *Stipa glareosa*, *Gleistogenes squarrosa*, *Agropyron cristatum*, *Allium polyrrhizumol* бүлгэмдэл, цав толгодоор чулуусаг алаг өвснөөс бүлгэмдэл үүсэн тархана. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн нийт хэмжээнд 17 овог 36 төрөлд хамаарагдах 44 зүйл ургамал бүртгэгдлээ. Овгуудын дотроос үетэн 2 зүйл, нийлмэл цэцэгтэн 8 зүйл, луультан 6 зүйлтэйгээр бусад овгийн ургамал 1-3 зүйлтэй тохиолдож байна. Түүнчлэн зүйлүүдийн дотроос 3 заримдаг сөөгөнцөр, 13 зүйл нэг наст ургамал байгаа бөгөөд 28 зүйл олон наст ургамал ургаж байна. Эмийн болон ашигт ургамал 19 зүйл бүх ургамлууд хадлан бэлчээрийн ач холбогдолтой. Тухайн нутгийн цаг уур, хөрсний онцлогоос хамаараад ургамлын нягтрал багатай, их сийрэг тачир. Ургамалшилт нь хөрсийг нийтэд нь бүрхэж чаддаггүй энд тэнд хэсэг хэсгээрээ ургадаг боловч шимт чанартай байдгаараа онцлог юм. Энд агь, таана, мангир, хөмүүл, хазаар, баглуур зэрэг олон наст ургамал, бударгана, харгана гэх мэтийн модлог, бутлаг говийн ургамал ургадаг. Хавар 4-р сараас ургамал ургаж цэцэг, навчаа дэлгэж эхлэх ба намар 9-р сараас гандах байдалтай болж ирнэ.

Ан амьтан

Чандмань сумын нутагт байрлах талбайн байгалийн хэв шинж нь мөлхөгч амьтын олон зүйл байрших тохиромжит нутаг юм. Тус талбайд сээртэн амьтаас загас, хоёр нутагтны ангийн төлөөлөгч тархцын хүрээнд тэмдэглэгдээгүй болно. Ашиглалтын талбай түүний орчим нутгийн шувуудын зүйлийн бүрдэл нь амьдрах орчны хэв шинж, улирлын ялгаатай байдал зэрэг биологийн хүчин зүйлээс хамаарч суурин үүрлэж, өндөглөдөг, мөн зөвхөн нүүдлийн үед дамжин өнгөрөх тул тоо толгой зүйлийн баялаг харилцан адилгүй. Тухайн район нь ан амьтадаар нэлээд баялаг, уул, асга, хадандаа аргаль угалз, янгир, ирвэс байдаг. Араатан амьтдаас үнэг, хярс, мануул, цөөн тооны чоно, мэрэгчдээс үлийн цагаан оготно, олби, орог саарал, шар сүүлт, алаг даага, туулай зэргийг нэрлэж болно. Жигүүртэн амьтдаас бүргэд, тас, элээ, хэрээ, харцага, идлэг шонхор, шар шувуу, сар, болжмор, ногтруу, ууль, тагтаа, чогчиго, хуланжороо зэргийг нэрлэж болно. Хэвлээр явагчдаас могой, замба, хонин ба могой гүрвэлүүд, шавж болон жижиг далавчтанаас арваалж, аалз, голио, царцаа зэргийг нэрлэж болно.

2. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

2.1.1 Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл

Цаг агаарын хуурай хуурайшилттай болон шуургатай өдрүүдэд уурхайд тэсэлгээ хийх, нүүрс олборлох болон тээвэрлэх үед тоос, хорт хий, уулын машин механизм, тоног төхөөрөмжийн дуу чимээгээр агаарын физик бохирдолт явагдаж болзошгүй, мөн тэсэлгээний үед болон шатах тослох материалын машин механизмын яндангаар хаягдах хорт хий хаягдах, химийн бодисын болон хатуу хог хаягдал зэргийн болзошгүй нөлөөгөөр агаар химийн нөлөөлөлд орох зэргээр давхардмал нөлөөлөлд орох магадлалтай. Уурхайн хаягдлын овоолго, нүүрсний овоолгын хэсгүүдээс салхиар дамжин агаарт тоосжилт үүсэх, автомашины хөдөлгүүрээс гарах утаа агаарын чанарын нөлөөлөл үүсгэж болзошгүй.

Агаар орчны бохирдолт:

- Хөрс хуулалт
- Нүүрс олборлолт
- Овоолго

Нөлөөлөлд өртөх объект

- Уурхайн түр хээрийн анги орчим
- Чандмань сум, багийн оршин суугчид
- Амьтан
- Ургамал

Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- Агаар дахь тоос болон хорт хийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- Тоос 0.5 мг/м³
- Нүүрстөрөгчийн дутуу исэл 5.0 мг/м³
- Алдегид 0.035-0.5

Ажиглалт, хяналт явуулах шаардлага

- Мэргэжлийн байгууллагаар агаарын сорьц дээж авхуулах, шинжилгээ хийлгэнэ.
- Мэргэжлийн өвчин судлалын үндэсний төвийн эмч нарын үзлэгт бүх ажиллагсдыг хамруулна.
- РМ_{2.5-10} тоосжилтын хэмжилт хийх

2.1.2 Хөрсний бохирдол

Хөрс, газрын гадарга нь уурхайн ашиглалтын үйл ажиллагаанаас талхлагдах, элэгдэх эвдэрхийн зэрэгцээ тоос, хатуу шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдож болзошгүй. Мөн хөрс хуулалт болон төслийн үйл ажиллагааны явцад хөрс эвдрэлд орохын зэрэгцээ үржил шимээ алдах сөрөг нөлөөлөл байна. Шатахуун түгээх станц, авто засварын төв зэрэг нь хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй тул талбайг цементлэх шаардлагатай.

Хөрсний бохирдол

- Ашиглалтын явцад хөрсний физик-механикийн болон химийн макро ба микро элементүүдэд өөрчлөлт орсон
- Хөрсний элэгдэл болон эвдрэл үүссэн
- Уурхайн малталт болон гадаад овоолгын суурийн талбайд шимт хөрс өртсөн
- Хүнд даацын машин, механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээсэн
- Хатуу болон шингэн хог хаягдлын улмаас хөрсөнд бохирдол үүссэн

Нөлөөлөлд өртөх объект

- Шимт хөрс бүхий газар
- Малын бэлчээр
- Амьтан ургамал

Стандарт, нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- БОЯ,ЭХБ-ны сайдын 1997 оны 143/А, 352/А тоот тушаалын 2,3,5-р хавсралт

Ашиглалт явуулах шаардлага

- Газрын төлөв байдал, хөрсний чанарын дээжийг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.
- Уулын ажлыг зөвхөн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэнэ.

2.1.3 Усны бохирдол

Газрын гадаргын болон газрын доорх усан орчин бохирдсон нөхцөлд тэр нь хөрсөөр дамжин хүрээгээ тэлж хөрс, хүн, мал амьтан, ургамалд сөргөөр шууд нөлөөлж болзошгүй. Газрын доорх усны ашиглалтаас усны нөөц багасах, усны түвшин буурах зэрэг нөлөөлөл үүсэж болзошгүй.

Гадаргын ба гүний ус

- Гадаргын ба гүний усанд одоогоор нөлөөлөл багатай

Нөлөөлөлд өртөх объект

- Хүн ба Мал

- Амьтан ургамал
- Стандарт, нормоор зөвшөөрөгдөх хэмжээ
- БОЯ, ЭМНХЯ-ны сайдын 1997 оны 143/А тоот тушаалын 2,3,5-р хавсралт
 - Гадаргын усны цэврийн ангилал

Ажиглалт явуулах шаардлага

- Ундны усны хяналт баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

2.1.4 Амьтны болон ургамлын аймагт үзүүлж болзошгүй нөлөөлөл

Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа, хөрс хуулалт, автомашины хөдөлгөөн зэргээс ургамал талхлагдах доройтох зэрэгцээ тоос, ахуйн хатуу, шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүнээр бохирдож ургамлан бүрхэвч багасах нөлөөлөл үүснэ. Уурхайн үйл ажиллагааны дуу чимээ, автомашины хөдөлгөөн зэргээс шувууд, амьтад уурхайн талбай болон ойр орчмын талбайгаас дайжих нөлөөлөл үүснэ.

Болзошгүй нөлөөллийн эх үүсвэр

- Уулын бэлтгэл ажлууд
- Уурхайн хөрс хуулалт ба карьер
- Өрөмдлөг, тэсэлгээ
- Олборлолт / нүүрс ачих тээвэрлэх /
- Хаягдал аж ахуйн /нүүрсний хаягдал, хаягдлын гадаад, дотоод овоолго /
- Талбайн гадаргын ус зайлуулах систем
- Шатах тослох материалын агуулах, шатахуун түгээх станц
- Зам, тээвэр
- Бохир ус цэвэрлэх байгууламж
- Хүн, машин механизм хөдөлгөөн

Нөлөөлөлд өртөх объект

- Уурхай орчмын ургамал амьтан

2.2 Сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, давтамж, нөлөөлөл, үргэлжлэх хугацаа

Зээгтийн нүүрсний уурхайн төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдал, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, түүний эрчимшлийг тодруулахын тулд Леопольдын матрицын аргыг ашиглав.

Хүснэгт 2. Леопольдын матрицын аргаар тооцсон нөлөөллийн үнэлгээ

Төслийн бүрэлдэхүүн	Барилга байгууламж барих үеийн барилгын материалын хаягдал	Химийн бүтээгдэхүүн /будаг, эмульс, шохой, цемент гэх мэт/	Авто тээврийн хэрэгсэл олшрох	Ой, хээрийн түймэр	Хүмүүсийн бөөгнөрөл	Хатуу хог хаягдал	Шингэн хаягдал	Ил задгай гал түлэх	Бүгд
Орчны үзүүлэлтүүд									
Агаарын бохирдол	+	+	+	+	-	++	+	+	8
Хотгор гүдгэрийн төрх	+	-	+	-	-	+	-	-	3
Гадаргын усны бохирдол	-	++	+	+	++	++	++	-	11

Газрын доорхи усны бохирдол	-	++	+	-	+	++	+++	-	9
Хөрс	++	+++	++	+++	+++	++	++	+	17
Ургамлан бүрхэвч	+	++	++	+++	+++	++	+	++	
Амьтны аймаг	-	+	++	++	+	+	+	+	
Шавж бичил биетэн	+	++	+	++	+	++	+	+	
Усны нөөц	-	+	-	-	-	-	-	-	

Дээрх үнэлгээнээс харахад тус нүүрсний орд нь уурхайн ашиглалтын үеийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хэмжээ их, тэдгээр нь өөр хоорондоо харилцан уялдаатай, нэг нь нөгөөдөө шууд болон дам байдлаар нөлөөлөх нь харагдаж байна. Гэхдээ энэхүү нөлөөллүүд дотор онц уршигтай сөрөг нөлөөлөл байхгүй. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгээс хөрс эвдрэх, ургамлан бүрхэвч талхлагдаж төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орох, хүн ам, машин техникийн бөөгнөрөл дуу чимээнээс ан амьтан үргэж дайжих зэрэг сөрөг нөлөөлөл үүсэж болох магадлалтай.

Гео орчин

Уурхайн малталт, тээвэрлэлт барилга байгууламж барих, угсрах суурьшил болон суваг шуудуу татах, нүх цооног ухах зэрэг газар шорооны бүх ажлаар тарчиг сийрэг, төрөл зүйл цөөн ургамалтай энэ газрын хөрс ургамлан нөмрөг эвдэрнэ. Нуралт, гулсалт, суулт үүсэж болох догол мөрөгцөгүүдтэй уурхайн малталтууд, өвс ургамалгүй элэгдэж талхлагдсан элс шороон зам, талбай бий болно. Мөн хөрс хуулалтын хоцрогдлоос шалтгаалан доод түвшингүүдийн зарим хэсэг дэх хажуугийн налуугийн ерөнхий өнцөг 45^0 –аас дээш болох тохиолдол гардаг нь гулсалт нуралт болох аюулд хүргэж болзошгүй юм.

Гадаргын ба газрын доорх ус

Чулуун нүүрсийг ил аргаар олборлох хэвийн нөхцөлийн хангах, нүүрсний чанарын сайжруулах зорилгоор түүний чийгийг багасгах, олборлолтын явцад уурхайн малталтын хана, ёроолоос шүүрэх хөрсний усыг гадагш насосоор татаж зайлуулна. Энэ нь аажимдаа газрын доорх ус буюу усны нөөцийн түвшинд нөлөөлөх магадлалтай.

Агаар орчин

Өрөмдлөг, тэсэлгээ, уурхайн малталт, гадаад овоолго, тээвэрлэлтийн зам, нүүрс олборлолт бутлалт, тээвэрлэлт, суурьшил хөдөлгөөнөөр элэгдэж, талхлагдсан хөрс газар болон технологийн бүх үйл ажиллагаатай холбогдож агаар орчин бохирдоно.

Хөрс, ургамал, биологийн төрөл зүйл

Төслийн талбай түүний ойр хавийн хөрс нүүрс олборлолтоор эвдрэх, элэгдэж талхлагдах нь ургамлын аймгийн зүйл төрөл доройтох, ургамлын бүрхэц ядуурах, өсөлт хөгжилт муудаж ургац буурах, шинэ орчинд зохицсон хөл ургамлын зүйл төрөл ургах зэрэг сөрөг нөлөө гарна. Ургамалшилтад нөлөөлөх өөр нэг хүчин зүйл бол орчны хөрсний ус чийгийн дутагдал юм. Хур тунадас багаас орчны чийг хангамж багасгах, гүний усны түвшин буурч, гадаргын урсац ширгэж үгүй болох зэргээс хөрсний үржил шим, ус чийг багасна. Энэ нь ургамлын бүрхэц буурах, төрөл зүйл цөөрөх нэг шалтгаан болно.

Нүүрсний ордыг ил аргаар олборлон ашиглах үед уурхайн малталт болон зам талбайд хөрс, ургамлын хамтаар амьтны аймаг ялангуяа шавж хорхой үе нугаламгүй амьтад, шавж идэштэн хийгээд бичил амьтад устаж үгүй болно.

**3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

“Сэкер Ресорсус Монголиа” ХХК -нь байгаль орчныг хамгаалах талаар Монгол улсын хууль тогтоомж, стандартуудыг даган мөрдөж, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-ний тайланд тусгагдсан зөвлөмж, зааврыг хэрэгжүүлэн төслийн үйл ажиллагааны явцад гарч байгаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлж ажиллана.

Мөн Монгол Улсын хууль тогтоомж, стандартад нийцүүлэн байгальд ээлтэй орчин үеийн технологи нэвтрүүлэх, байнгын хяналт, мониторинг хийх, олборлолтын бүхий л үе шатанд эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны стандартуудыг хэрэгжүүлэх замаар байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хангасан байгаль орчны зохистой бодлого барин ажиллахаар зорьж тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 70 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

ЗЭЭГТИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, /төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1. Агаарын чанар									
1.1	Тээврийн хэрэгслийн яндангаас утаа болон хорт хий ялгарах.	Түлшний чанарын хяналт хийлгэх, техникийн үзлэг оношилогоог тогтмол тогтоосон хугацаанд хийж байх	Тээврийн хэрэгслийн орчимд	ширхэг	125,000	4	500,000	Жилд 1 удаа	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Агаарын тухай хууль MNS4585:2016 стандарт (агаар)
1.2	Ил уурхайн ашиглалтын үйл ажиллагааны үед эвдэрсэн газруудаас салхи ба техникийн нөлөөгөөр тоос үүсэх.	Тоосны дэгдэлтийг бууруулах зорилгоор төслийн үйл ажиллагааны туршид зам усалгааг тогтмол хийх	Уурхайн тээврийн зам, овоолго	М³	99.74	-	2,000,000	Олборлолт явуулж эхлэх үед	
	Уурхайн дотоод тээврийн замаас тоосжилт үүсэх	Уурхайн дотоод шороон замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор засвар арчилгааны тогтсон хуваарийг гаргаж, хуваарийн дагуу замыг	Уурхайн дотоод зам	-	-	-	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	

ЗЭЭГТИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

		засаж сайжруулах, нягтаршуулах							
2. Гадаргын ба газрын доорх усны нөөц									
2.1		Байгаль хамгаалах сургалтаар Ус ашиглалт, хэрэглээний талаар мэдээлэл хүргэх	Нийт ажилтнууд	Сургалт	ҮАЗ	Тухай бүр	-	Шинэ ажилтны сургалт	Усны тухай хууль
2.2	Уурхайн ус шүүрүүлэлт, усны хэрэглээнээс газар доорх усны нөөцийн хомсдол үүсэх	Дэлхийн усны өдөрлөгөөр уурхайн хүрээнд усны хэрэглээг бууруулах, ариг гамтай ашиглах талаар нийт ажилчдад сургалт зохион байгуулж, хэрэгжилтийг хянах	Нийт ажилтнууд	Сургалт	-	-	-	Дэлхийн усны өдөр	
2.3	Химийн бодисууд, ШТМ зэрэг хор аюул бүхий бодис материалууд осол эрсдэл, хүний санамсар болгоомжгүй үйлдлийн улмаас асгарсан тохиолдолд	Төслийн байрлах талбайн хэмжээнд уст цэгүүд, цооногуудаас дээж авч тогтмол хяналт шинжилгээ хийлгэх, хүлцэх хэмжээнээс давсан тохиолдолд эх үүсвэр, шалтгааныг тодорхойлж бууруулах арга хэмжээг авах	Төслийн талбайн уст цэг	ОХШХ-т тусгасан				Үйл ажиллагаа хэвийн явагдах үед	

ЗЭЭГТИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

2.4	усан орчныг бохирдуулах.	Сумын ундны усанд чанар хүртээмжийн судалгаа хийх, стандартад заасан хүлцэх хэмжээнээс давсан үзүүлэлтэд холбогдох арга хэмжээ авах	Сумын худаг	ОХШХ-т тусгасан				Үйл ажиллагаа хэвийн явагдах үед	
2.5	Бохир усны цэвэршүүлэлт стандарт шаардлагад нийцээгүй үед усан орчин бохирдох	Хаягдал найрлагад усны тоо хэмжээ, хяналт тавьж, шинжилгээ хийлгэх	Төслийн талбайн бохирын танк	ОХШХ-т тусгасан					
3. Хөрсөн бүрхэвч									
3.1	Шимт хөрсний хадгалалт хамалалт алдагдах	Шимт хөрсийг стандартын шаардлагын дагуу хуулах, хадгалах талбайн захын цэгүүдийг тэмдэгжүүлэх,	Шимт хөрсний овоолго,	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан					MNS5916:2008 газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
3.2	Шатах тослох материалаас хөрс бохирдох	ШТМ-н хадгалалт тээвэрлэлтэд хяналт тавьж, асгаралт үүсэж бохирдсон хөрс саармагжуулах талбай бэлдэх	Уурхайн хэсэг	м ²	10,000	30*30мкв хэмжээтэй талбай	9,000,000	2 дугаар улиралд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль

ЗЭЭГТИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

3.3		Кемпийн генератор, Шатахуун түгээгүүрийн түлш олгох хэсэгт ШТМ-ын асгаралт үүсэж хөрс бохирдохоос сэргийлэх арга хэмжээ авах, бетон суурьтай болгох	Генератор, Шатахуун түгээгүүр орлого зарлагын хэсэгт	2	1,250,000	1	2,500,000	1 дүгээр улиралд	
4. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн бууруулах									
4.1	Уурхайн үйл ажиллагаанд ухагдах, дарагдах, талбайн бүх ургамлан бүрхэвч устгах	Аливаа газар хөндөлт бүрийн өмнө тухайн талбайн ургамлан нөмрөгийн суурь мэдээллийг цуглуулж, нөхөн сэргээлтийн ажилд аль болох тухайн нутгийн ургамлын үрүүдийг ашиглаж, байгалийн бүлгэмдлийг дахин сэргээх арга хэмжээ авах.	Төслийн талбай	удаа	-	-	ХОЗ	Ургамал ургалтын хугацаанд	Авто замын тухай хууль
4.2		Кемпийн 0.35га талбайг ургамалжуулах, хайлаас, улиас болон бусад түргэн ургалттай навчит мод тарьж ургуулах	Уурхайн туслах барилга байгууламжийн ашиглалтын талбайн 10%-тай тэнцэх газар	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгасан			5 дугаар сард	Газрын тухай хууль, БОА-ийн зөвлөмж	
5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах									

ЗЭЭГТИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

5.1	Амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Зуд болон ган гачигтай үед зэрлэг ан амьтдад өвс, тэжээл, хужир, мөс тавьж өгөх зэргээр ойр орчмын ан амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төслийн талбайн ойр орчимд	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд тусгасан				11 дүгээр сард	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хууль
5.2		Уурхайн ухаш, нүхэнд зэрлэг амьтан унах, олборлолт явуулж буй хэсэгт хүн, мал, амьтан орох, унаж бэртэхээс урьдчилан сэргийлж шаардлагатай газруудад хашаа барих, шороон хаалт хийх	Мал амьтан унаж болзошгүй газруудад	М	2000	1000	Хөрөнгө оруулалтын зардлаас	Олборлолтын ажил эхлэхээс өмнө бэлэн болгох	
5.3		Ховор болон нэн ховор амьтад, тэдгээрийн нүүдэл хөдөлгөөний талаар жолооч нарт төслийн талбайн гадна болон дотор талд анхаарал болгоомжтой зорчих талаар сургалт зохион байгуулах	Төслийн талбай орчим болон тээвэрлэлтийн зам дагуу	Ширхэг	ҮАЗ	Тогтмол	-	Сар бүр	
5.4		Төслийн талбай болон түүний ойр орчимд зэрлэг амьтны тархац, нөөцийг үнэлэх зорилгоор шугаман	Төслийн талбай	удаа	ОХШХ-т тусгасан			Жилд 1	

ЗЭЭГТИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

		замналын судалгаа хийх, шувуудын судалгаа, махчин шувуудын үүрний байршлыг тогтоох зэргээр хяналт мониторингийн ажлыг гүйцэтгэхэд сумын байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагч нартай хамтарч ажиллах							
	Нийт						14,000,000		

ЗЭЭГТИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уулын ажлын төлөвлөгөөнд гадаад дотоод овоолгын техникийн нөхөн сэргээлт төлөвлөөгүй.

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичгүүд
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний хадгалалт хамгаалалтыг стандартын дагуу гүйцэтгэх	Усалгаа хийх, олон наст ургамал тариалах	Овоолго	2	2,750,000	5,500,000	Ургамал ургалтын хугацаанд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4 MNS
2	Кемпийн газрын 0,35 га талбайд мод тарих, ногоон байгууламж бий болгох	Олон наст тарих	Олон наст өвлөг ургамал тарьж ургуулах	га	0,35	1,500,000	1,500,000	2024оны 5 дугаар сар	Газрын тухай хууль, БОА-ийн зөвлөмж
3	Тэр бум мод хөтөлбөр хэрэгжүүлэх	Хиймэл нуурын ногоон байгууламжийн талбай нэмэгдүүлэх	Хайлаас, улиас болон бусад түргэн ургалттай навчит модоор хамгаалалтын зурвасны талбайн хэмжээг нэмэгдүүлэх	ш	5,000	3,000	15,000,000	2024 оны 5 дугаар сар	МУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг
Арга хэмжээг хэрэгжүүлэх зардал: 22,000,000төг									

ЗЭЭГТИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Зэрлэг ан амьтдад зориулан аж ахуйн аргаар хөв байгуулах	Өмнө нь хашиж хамгаалсан булгийг түшиглэн аж ахуйн аргаар хөв хийх	Боргиотын булаг	1	-	-	Жилд 1 удаа	Усны тухай хууль
2	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, эзэнгүй орхигдсон газарт техникийн нөхөн сэргээлт хийх	Техникийн нөхөн сэргээлт	Самдандамба уулын эвдэрсэн газарт	10 га хүртэл	4,000,000	Гүйцэтгэгчийн дотоод зардлаас	2025 оны 11 дүгээр сарын 1-ний дотор	MNS 5917 2008 стандарт
3.	Биотехникийн арга хэмжээ	Өвс тавьж өгөх	Чандмань уул	100	20,000	2,000,000		
	Нийт					2,000,000		

8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбогдох харилцааг зохицуулах зорилттой Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, археологийн хайгуул судалгаа, археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажлыг 2011-2012 онуудад, 2023 онд палеонтологийн судалгаа, 2024 онд усгаатны зүйн судалгааг тус тус хийлгэж Шинжлэх ухааны академийн холбогдох хүрээлэнгүүдээр дүгнэлт гаргуулсан.

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Соёлын биет өв	Шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааг түр зогсоож холбогдох газарт мэдээлэх	Мэдээлэл хүргэх, авран хамгаалах арга хэмжээ зохион байгуулах	1	100,000	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
2.	Соёлын биет бус өв			1	100,000	ҮАЗ		
3.	“Соёлын өвийг хамгаалах тухай” сэдэвт сургалт	Шинэ ажилтны сургалтаар мэдээлэл хүргэх	Сургалт, мэдээлэл	Тогтмол	-	-		
	Нийт					ҮАЗ		

9. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (сая.төг)	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1. Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр							
Хүчтэй салхи шуурганаас аюул, осол гарах	Аяллын үеийн аюулгүйн хэрэгсэл бүрдүүлэх	Холын аялалд гарах машинд урьдчилан сэргийлэх бүрдэл	3	5,0	ХАБЭА-н зардлаас	1 дүгээр улирал	Компанийн аяллын журам, Гамшгаас хамгаалах тухай хууль
	Уурхайд онцгой байдал, осол эрсдэлийн үед “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г боловсруулан, жил бүр сайжруулж мөрдөн ажиллах	Төсөл хэрэгжүүлэгч	1	-	-	1 дүгээр улирал	Компанийн аяллын журам, Гамшгаас хамгаалах тухай хууль
	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулуулж, ажилчдыг дадлагажуулах	Төсөл хэрэгжүүлэгч	1	5,0	ХАБЭА-н зардлаас	4 дүгээр улиралд багтаан	
2. Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр							
Ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж олборлолтын үйл ажиллагаа доголдох, зогсох	Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм журмууд боловсруулж, дагаж мөрдөх	Уурхайн ажилчид	ХАБЭА-н төлөвлөгөөгөөр	-	ХАБЭА-н зардлаас	1 дүгээр улирал	ХАБЭА-н тухай хууль
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах		Үйл ажиллагааны турш	-			MNS 4969:2000

ЗЭЭГТИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

	Ажиллагсдыг ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах	Уурхайд ажиллах ажилчид	Ээлжээр болон томилолтоор ажиллах ажилчдын тоогоор	3,0	ХАБЭА-н зардлаас	1 дүгээр улирал	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
3. Гал түймэр, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх							
Гал түймрийн аюулаас хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрах	➤ Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулж, мөрдөж ажиллах	Төслийн талбай	1	Гэрээний дүнгээр	ХАБЭА-н зардлаас	1 дүгээр улирал	Гамшгийн тухай хууль,
	Шаардлагатай байршлуудад иж бүрэн галын саравч, гал унтраагуур байрлуулах	Кемп, түр ШТС	3 ба түүнээс дээш	3,0	ХАБЭА-н зардлаас	1 дүгээр улирал	
	Түр шатахуун түгээгүүрийн ойр орчимд иж бүрэн галын саравч байрлуулах	ШТС	1	2,0	ХАБЭА-н зардлаас	1 дүгээр улирал	Галын аюулгүй байдлын тухай хууль
Төслийн болзошгүй эрсдэлийг бууруулах чиглэлээр хийгдэх ажлын нэг жилийн нийт зардал:						ХАБЭА-н зардлаас	

ЗЭЭГТИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	Энгийн хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөр хураамжийг гэрээнд заасан хугацаанд төлөх	Кемпийн хог хаягдал	Тн	300,000	Жилд 1 удаа төлбөр төлнө	300,000	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль Хог хаягдлын тухай хууль
2		Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах хог хаягдлыг дахивар авах цэгт нийлүүлэх		Тн	200,000	4	500,000		
3		Хог хаягдлын ангилах, ачих цуглуулах, технологид нийцсэн хогийн сав байрлуулах		Ш	20,000	10	200,000		
4	Аюултай	Эрх бүхий байгууллагад ААХ-г нийлүүлэх гэрээ байгуулах,	Төхөөрөмжөөс гарах АХХ, ШТМ-ын АХХ,	ш	-	1	-		

ЗЭЭГТИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

5		АХХ-г хаягдлыг бүртгэх, тогтоосон хугацаанд тээвэрлүүлэх	Үйлдвэрлэлийн хог хаягдал, ШТМ-н хаягдал	тн	850,000	2	1,900,000	Үйл ажиллагааны турш	
6	Хог хаягдлын анги-лан ялгах дадал зуршил хэвшүүлэх	Гадаад орчны хог хаягдлыг түүх, (Иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох)	Кемп-Уурхай хооронд	улирал	100,000	1	100,000	Үйл ажиллагааны турш	
7		Сургалт зохион байгуулах	Байгаль хамгаалах сургалт нийт ажилчдад	Ширхэг	ҮАЗ	1	-	Үйл ажиллагааны турш	Хог хаягдлын тухай хууль
	Нийт	3,000,000							

ЗЭЭГТИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж ийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Хөрсний физик, химийн шинж чанар, Хүнд метал -11 цэгт (хог хаягдлын цэг-нянгийн шинжилгээ)	1. Оффис, кемп 2. Зам дагуу /Уурхай-кемп/ 3. Шимт хөрс 4. Карьер орчим 5. Зогсоол /кемп/ 6. Зогсоол /карьер/ 7. Засварын газар 8. ШТС 9. Нөлөөлөлд өртөөгүй талбай 10. Хогийн цэг /засвар/ 11. Хогийн цэг /Кемп-Хөрсний нянгийн шинжилгээ/	Жилд 2 удаа	2	90,000	1,980,000	Үйл ажиллагаа явуулах үед	Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 2019
2	1.Ундны усны ерөнхий химийн шинжилгээ, нянгийн шинжилгээ-4шинжилгээ	1. Ундны ус 2. Сумын худгийн ус-2 ширхэг 3. Ахуйн бохир ус		2	50,000	400,000	Үйл ажиллагаа явуулах үед	Ундны усны чанарын стандарт MNS 900:2018
3	Агаар дахь Тоос pm 2.5 pm 10 Нийт тоос	1. Оффис, кемп 2. Зам дагуу /Уурхай-кемп/		2	120,000	2,160,000	Үйл ажиллагаа явуулах үед	Агаарын чанар, техникийн ерөнхий

ЗЭЭГТИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

	SO ₂ NO ₂ CO Дуу чимээ Нийт -9 цэгт	3. Зам дагуу /Уурхай-сум/ 4. Карьер орчим 5. Овоолго /отваль/ 6. Засварын газар 7. ШТС 8. Нөлөөлөлд өртөөгүй талбай 9. Сумын төв						шаардлага: MNS 4585:2007
4	Сумын унды усанд чанар, хүртээмжийн судалгаа хийх, сумын худгийн усанд шүүлтүүр суурилуулах	Сумын 2 худаг	Жилд 1	2	3,230,000	6,460,000	Үйл ажиллагаа хэвийн явагдаж эхлэх үед	Аймгийн Засаг даргын зорилт
5	Ургамал амьтны судалгааг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Төслийн талбайн ойр орчимд	Жилд 1	1	Гэрээний дүнгээр	Гэрээний дүнгээр	Хөндлөнгийн хяналтын үед	Ургамлын тухай хууль Амьтны тухай хууль
6	Мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт хийлгэх,	Үр дүнг урьд онтой харьцуулан дүгнэлт хий	Жилд 1 удаа	1	Дотоод	14,000,000	Биелэлтийн тайланд тайлагнах	Гэрээний дагуу
	Нийт					25,000,000		

ЗЭЭГТИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
	1	2	3	6	7
1.	Нийт ажилчдыг урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамруулах	4,000,000	Үйл ажиллагааны туршид	ХАБЭА-н мэргэжилтэн Хүний нөөцийн мэргэжилтэн	Нийт ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулна.
2.	Нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, холбогдох гэрээ байгуулах	Гэрээний дүнгээр	2025 оны 1 дүгээр улиралд	Удирдлага Уурхайн дарга Орон нутагтай харилцах алба	1 дүгээр улиралд багтаан Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах
3.	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр холбогдох журам боловсруулж, мөрдөж ажиллах	-	Үйл ажиллагааны туршид	Байгаль орчны мэргэжилтэн	Өнгөн хөрстэй ажиллах журам Хог хаягдлын журам
4.	Байгаль орчны аудитын зөвлөмжөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайланг тайлагнан ажиллах	-	11 дүгээр сарын 1	Байгаль орчны мэргэжилтэн	БОМТ-ний биелэлтийн хамт тайлагнах
5.	Ус ашиглах дүгнэлт гаргуулах, Зөвшөөрөл авч гэрээ байгуулах, Ус ашиглалтын тайлан гаргаж, гэрээ дүгнүүлэх	Дүгнэлт болон гэрээнд заасан дүнгээр	УАТ батлагдсаны дараа	Байгаль орчны мэргэжилтэн	Усны тухай хууль 28.4
	Нийт	4,000,000			

ЗЭЭГТИЙН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ-2025 ОН

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Орон нутгаас ажиллаж байгаа ажилчдад тухайн жилийн БОМТ танилцуулах	танилцуулга	Тухайн жилийн БОМТ-ний биелэлт	4 дүгээр улиралд	-	Байгаль орчны мэргэжилтэн Уурхайн дарга	Уурхай
2	Нөлөөллийн бүсийн иргэд, БИНХ-д тухайн жилийн БОМТ-ний биелэлт танилцуулах	Танилцуулга, тайлан	Тухайн жилийн БОМТ-ний биелэлт, үйл ажиллагааны танилцуулга	4 дүгээр улиралд	-	Байгаль орчны мэргэжилтэн Уурхайн дарга	Сумын иргэний танхим
3	Чандмань сумын Засаг даргад тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн хураангуй хүргүүлэх	Хураангуй тайлан хүргүүлэх	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн хураангуй танилцуулга	4 дүгээр улиралд	-	Байгаль орчны мэргэжилтэн Уурхайн дарга	ЗДТГ
4	Говь-Алтай аймгийн БОГ-т тайлан хүргүүлэх	Дэлгэрэнгүй тайлан	Дэлгэрэнгүй тайлан хүргүүлэх	11 дүгээр сарын 1-ний дотор	-	Байгаль орчны мэргэжилтэн	Говь-Алтай аймаг
5	БОУАӨЯ-д цахимаар илгээх	Дэлгэрэнгүй тайлан	Дэлгэрэнгүй тайлан илгээх	11 дүгээр сарын 1-ний дотор	-	Байгаль орчны мэргэжилтэн	Eic.mn
	Нийт						

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН
ЗАДАРГАА

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Нийт зардал / төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	14,000,000
2	Нөхөн сэргээлт	22,000,000
3	Дүйцүүлэн хамгаалах ажил	2,000,000
4	Түүх соёлын өвийг хамгаалах	Үйл ажиллагааны зардлаас
5	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	ХАБЭА-н зардлаас
6	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,000,000
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	25,000,000
8	БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	4,000,000
	Нийт зардал	70,000,000